



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО**

2023

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

Судалгааг хянасан:

Г.Давааням

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LLD.)

Судалгааг удирдсан:

Б.Түмэндэмбэрэл

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)

Судалгааг гүйцэтгэсэн:

Э.Сэлэнгэ

Эрдэм шинжилгээний ажилтан

С.Мягмарсүрэн

Эрдэм шинжилгээний ажилтан

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	3
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	5
Нэг. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох.....	11
Хоёр. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох.....	16
Гурав. Гаргах зардлыг урьдчилан тооцох	23
Дөрөв. Үр дүнг тооцох.....	24
Тав. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.....	26
ИРГЭНД УЧРАХ ЗАРДЛЫН ТООЦОО	28
Нэг. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох	28
Хоёр. Зардал тооцох.....	28
Гурав. Тоон үзүүлэлтийг тооцох.....	30
Дөрөв. Зардлын дүнг тооцож гаргах	30
Тав. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах	31
Зургаа. Нэмэлт зардлыг тооцох	31
ДҮГНЭЛТ, САНАЛ	32

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ/

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэх хүрээнд иргэн, төрийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдуулан энэхүү төсөлд тусгасан үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай гаргах зардлыг тооцож, тэдгээрт ногдох зардал, үйл ажиллагааны ачааллыг багасгаж, зохицуулалтын боломжит хувилбарыг боловсруулахад энэхүү зардлын тайлангийн гол зорилго нь оршино.

Монгол Улсын хувьд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан. Урт хугацааны хөгжлийн бодлогын “Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, засаглалын тогтвортой байдлыг хангана” гэсний Зорилт 5.1-ийн хүрээнд I үе шат буюу 2021-2030 онд төрийн бодлого, үйл ажиллагааны тогтвортой байдалд эерэг нөлөөтэй сонгуулийн тогтолцоо бүрдүүлэх, тодруулбал Улсын Их Хурлын сонгуулийг холимог системээр явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх тодорхой зорилтыг дэвшүүлсэн билээ.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны суурь өөрчлөлт, хуулиар зохицуулах харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлах, боловсронгуй болгох хэрэгцээ шаардлагад үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах бөгөөд хуулийн төсөлд дараах харилцааг зохицуулахаар тусгасан байна. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 38 гишүүнийг хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос, 38 гишүүнийг энэ хуульд заасны дагуу сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаас тус тус сонгох сонгуулийн хосолсон тогтолцоотой байхаар тусгаж, үүнтэй холбоотойгоор нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх, саналын хуудсыг хэвлүүлэх, сонгогч санал өгөх, түүнийг тоолох, дүн гаргах, суудал хуваарилах зэрэг харилцааг нарийвчилсан зохицуулалт;
2. Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож, санал өгөх эрхтэй байхаар тусгаж, үүнтэй холбоотойгоор гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг зохион байгуулах байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагын бүтэц, бүрэн эрх, ажиллах журам, гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, санал авах, тоолох харилцааг нарийвчилсан зохицуулалт;
3. Улс төрийн намын бүртгэл, өөрчлөлттэй холбоотойгоор нам сонгуульд оролцохоо илэрхийлэх, хүлээн авах, бүртгэх үйл ажиллагаатай холбоотойгоор гардаг хүндрэл, эрх зүйн тодорхойгүй байдлыг арилгах талаарх нарийвчилсан зохицуулалт;

4. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах үйл ажиллагааны ил тод, нээлттэй, хяналттай байдлыг нэмэгдүүлэх, уг үйл ажиллагаанд төрийн байгууллага болон сонгуульд оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр зохицуулалт;
5. Санал авах өдөр өөрийн харьяа хэсгийн хороонд саналаа өгөх боломжоор бүрэн хангагдаж чаддаггүй сонгогчид болох оюутан, ээлжийн ажил хийдэг зэрэг сонгогчдын сонгох эрхийг хангах шаардлагад үндэслэн урьдчилан санал авах ажиллагааны талаарх зохицуулалт;

Дээрх нэмэлт, өөрчлөлтэй холбоотойгоор хэрэгжилтийн зардал гарах тул холбогдох тооцооллыг гүйцэтгэсэн болно. Ингэхдээ зардлыг тооцоог Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 18.1 дэх хэсэгт тусгаснаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-д дурдсаны дагуу хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй гарах зардал, нөлөөллийг эрх зүйн зохицуулалтад хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардал тус бүрээр тооцон боловсруулсан болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгжилттэй холбогдон гарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардлыг нэмэлт өөрчлөлт орсон зүйл заалт тус бүрээр тооцон боловсруулсан. Өөрөөр хэлбэл одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжид хэвээр үлдсэн зохицуулалтууд нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад нэмэлтээр зардлын нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзсэн.

Энэхүү зардлын тооцооны тайлан нь дараах үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Төрийн байгууллагын зардлын тооцоо
2. Иргэнд учрах зардлын тооцоо

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3. Гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан төрийн захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг дараах байгууллагууд гүйцэтгэхээр байна.

1. Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо
2. Улсын бүртгэлийн байгууллага
3. Төв комисс
4. Салбар комисс
5. Сонгуулийн хэсгийн хороод

/Хүснэгт 1/

Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын зардалд нөлөөлөх зүйл заалт

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэх холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт	Чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага
<p>4.3.1.Монгол Улсын Их Хурлын 38 гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос;</p> <p>4.3.2.Монгол Улсын Их Хурлын 38 гишүүнийг энэ хуульд заасны дагуу сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаас.</p>	<p>74.1.Энэ хуулийн 4.3.1-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшигчийн санал хураалтын дүн гаргах.</p> <p>74.1.1.Сонгуулийн ерөнхий хороо нь санал хураалтын дүнг үндэслэн тухайн тойрогт нэр дэвшсэн нийт нэр дэвшигчдийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана.</p> <p>74.1.2.Хамгийн олон санал авсан, тухайн тойрогт ногдох мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийг Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцно.</p> <p>74.2.Энэ хуулийн 4.3.2-т заасан нээлттэй жагсаалтаар нэр дэвшигчийн санал хураалтын дүн гаргах.</p> <p>74.2.1.Сонгуулийн ерөнхий хороо нь санал хураалтын дүн болон энэ хуулийн 71 дүгээр зүйлийн 71.11-д заасныг үндэслэн нам, эвсэл тус бүрээр авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргана.</p>	<p>Сонгуулийн Ерөнхий Хороо</p>

	<p>74.2.2.Энэ хуулийн 74.2.1-д заасны дагуу гаргасан жагсаалтыг үндэслэн нам, эвсэл тус бүрээр нь тухайн нам, эвслийн авсан саналын тоо болон хувийг гаргана.</p> <p>74.2.3.Энэ хуулийн 74.2.2-т заасныг үндэслэн бүх нам, эвслийн авсан нийт саналын 3 буюу түүнээс дээш хувийн санал авсан нам, эвслийг авсан саналын хувиар нь дараалалд оруулан жагсаалт гаргана.</p> <p>74.2.4.Энэ хуулийн 74.2.3-д заасан 3 хувийн босгыг даваагүй нам, эвслийн авсан нийт саналын хувийг тэнцүү хэмжээгээр хуваан энэ хуулийн 74.2.3-т заасан жагсаалтад орсон нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувь дээр нэмж тооцно.</p> <p>74.2.5.Энэ хуулийн 74.2.4-т заасны дагуу тооцож гаргасан хувиудын нийлбэрийг 38-д хувааж нэг суудалд ногдох саналын тоо, хувийг тооцож гаргана.</p> <p>74.2.6.Энэ хуулийн 74.2.4-т заасны дагуу тооцож гаргасан нам, эвсэл тус бүрийн авсан саналын хувийг энэ хуулийн 74.2.5-д заасны дагуу тооцож гаргасан нэг суудалд ногдох саналын хувьд хувааж Улсын Их Хурлын гишүүний 38 суудлыг их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилна.</p> <p>74.3.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 74.1, 74.2-д заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр гаргаж, Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлнэ.</p> <p>74.4.Сонгуулийн ерөнхий хороо нь Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.</p> <p>75.5.Тойрогт нэр дэвшиж энэ хуулийн 75.3-т заасны дагуу Улсын Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо хүчингүйд тооцсон бол дахин санал хураалт явуулна.</p>	
<p>5.2 Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар /цаашид “Дипломат төлөөлөгчийн газар” гэх/ байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх</p>	<p>Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комиссын бүрэн эрх</p> <p>19.1.Сонгуулийн ерөнхий хороо, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг харгалзан гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий төв комиссыг гадаадад санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга болон ес, эсхүл арван нэгэн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.</p>	<p>Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын</p>

<p>бүхий иргэн сонгуульд оролцож, санал өгөх эрхтэй.</p>	<p>19.2.Төв комисс нь салбар комиссыг гадаадад санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө дарга болон хоёр, эсхүл дөрвөн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дипломат төлөөлөгчийн газрын дэргэд байгуулна.</p> <p>19.4.Төв комиссыг ажиллах байр, нөхцөл, боломжоор хангах үүргийг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбар комиссыг ажиллах байр, нөхцөл, боломжоор хангах үүргийг тухайн улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар хүлээнэ.</p> <p>19.5.Төв комисс нь Сонгуулийн ерөнхий хорооны шууд удирдлагын доор сонгуулийн санал авах ажиллагааг зохион байгуулна.</p> <p>19.6.Салбар комисс нь төв комиссын шууд удирдлагын доор гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулна.</p> <p>19.8.Салбар комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>19.8.1.салбар комиссын буюу санал авах байрын хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;</p> <p>19.8.2.өөрийн байрладаг улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийг бүртгэж, сонгогчдын бүртгэлийг гарган төв комисст хүргүүлэх;</p> <p>19.8.3.санал авах байр, саналын хайрцаг, санал бэлтгэх бүхээг, санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;</p> <p>19.8.4.санал хураалт дууссаны дараа битүүмжилсэн дугтуйтай саналын хуудас, санал авахад зарцуулагдаагүй үлдсэн, хураагдсан, хүчингүй саналын хуудас, санал хураалтын тухай салбар комиссын хуралдааны тэмдэглэл, сонгуулийн бусад баримт бичгийг төв комисст олон улсын буухиа шуудангаар нэн даруй хүргүүлэх;</p> <p>19.8.5.өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, бичгээр хариуг өгөх;</p>	<p>Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар</p>
<p>9.3.Гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдөр /цаашид "гадаадад санал авах өдөр" гэх/-ийг энэ хуульд заасны дагуу тогтоосон сонгуулийн санал авах өдрийг үндэслэн гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах төв комиссын саналыг харгалзан</p>	<p>20.12.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуульд нийцүүлэн гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх журмыг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн батална.</p> <p>64.1.Гадаад улсад байгаа сонгогчийн саналыг Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон санал авах өдөр, тухайн улсын орон нутгийн цагаар</p>	<p>Сонгуулийн Ерөнхий хороо</p>

<p>сонгуулийн төв байгууллага /цаашид "Сонгуулийн ерөнхий хороо" гэх/ тогтоох бөгөөд санал авах өдөр нь хоёр хүртэл өдөр байж болно.</p>	<p>07:00 цагаас 22:00 цаг хүртэлх хугацаанд салбар комиссын тогтоосон санал авах байранд авна.</p> <p>64.2.Салбар комисс нь санал авах өдөр, цаг, байрыг санал авах өдөр хүртэлх хугацаанд гадаад улсад байгаа сонгогчдод зарлан мэдээлнэ.</p> <p>64.3.Сонгогчоос саналаа нууцаар өгөхөд шаардагдах санал бэлтгэх бүхээг бүхий байр, саналын хайрцгийг санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө энэ хуульд заасны дагуу тухайн улсад байгаа Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн хариуцаж, бэлтгэнэ.</p> <p>64.4.Санал авах байранд сонгогчоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хүрэлцэхүйц тооны санал бэлтгэх бүхээг бэлтгэсэн байна.</p> <p>64.5.Гадаад улсад байгаа сонгогчийн саналыг Сонгуулийн ерөнхий хорооноос хүргүүлсэн саналын хуудсаар авна.</p> <p>64.6.Сонгуулийн ерөнхий хороо нь саналын хуудсыг уутны хамт битүүмжлэн, төв комиссоор дамжуулан гадаад улсад байгаа сонгогчдын санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө салбар комисст хүргүүлнэ.</p> <p>64.7.Салбар комисс нь саналын хуудсыг бүрэлдэхүүнээрээ хүлээн авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж гарын үсэг зурна.</p> <p>67.1.Салбар комиссын бүрэлдэхүүн гадаадад санал авах өдөр тухайн улсын орон нутгийн цагаар 07:00 цагт ажиглагч, эсхүл сонгогчийн төлөөллийг байлцуулан саналын хайрцгийг нээж харуулан, шалган битүүмжилж, лацадсаны дараа салбар комиссын дарга дараах мэдээллийг хийж тэмдэглэл хөтлүүлнэ:</p> <p>67.1.1.сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчийн тоо;</p> <p>67.1.2.хүлээн авсан, алдагдаж үрэгдсэн, устгагдсан, үлдсэн саналын хуудасны тоо;</p> <p>67.1.3.саналын хуудасны нэгдсэн дугаар.</p> <p>67.2.Салбар комисс энэ хуулийн 67.1-д заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа санал авах ажиллагааг эхлүүлэх бөгөөд ингэхдээ сонгогчийн иргэний үнэмлэх, эсхүл үндэсний гадаад паспортыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэж, сонгогч бүрд саналын хуудсыг дугтуйн хамт олгоно.</p> <p>67.3.Саналын хуудас авсан сонгогчоор сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зуруулна.</p> <p>67.4.Гадаад улсад байгаа иргэдийн санал авах бусад ажиллагаанд санал авах байранд санал авах журмыг баримтална.</p>	
---	--	--

	<p>67.5.Салбар комисс санал авах ажиллагааны тухай тэмдэглэл хөтөлж бүх бүрэлдэхүүн гарын үсэг зурж, тэмдэг дарах бөгөөд тэмдэглэлд дараах мэдээллийг заавал тусгана:</p> <p>67.5.1.сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчийн тоо;</p> <p>67.5.2.саналын хуудас авсан сонгогчийн тоо;</p> <p>67.5.3.саналын хуудас дахин авсан сонгогчийн тоо;</p> <p>67.5.4.ажиглагчийн нэрс;</p> <p>67.5.5.санал авах өдрийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл.</p> <p>67.6.Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн энэ хуулийн 4.3.2-т заасан нам, эвсэл тэдгээрээс жагсаалтаар нэр дэвшигчид саналаа өгнө.</p> <p>67.15.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглахтай холбогдсон харилцаанд сонгууль ажиглах ерөнхий журмыг баримтална.</p> <p>67.16.Ажиглагч томилох эрх бүхий этгээд гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаанд хоёр хүртэл ажиглагчийг томилон ажиллуулж болно.</p> <p>67.17.Ажиглагч томилох эрх бүхий этгээд гадаад улсад байгаа сонгогчдоос санал авах ажиллагаанд ажиглагч томилох бол энэ тухай хүсэлтээ төв комисст хүргүүлнэ.</p> <p>67.18.Төв комисс нь гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг ажиглахаар томилогдсон ажиглагчийн мэдээллийг холбогдох салбар комисст хүргүүлэх бөгөөд ажиглагч нь гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрөөс ажлын гурваас доошгүй хоногийн өмнө салбар комисст бүртгүүлж, ажиглагчийн үнэмлэх авна.</p> <p>Сонгогчийг санал өгсний дараа санал авах байранд өгсөн саналынх нь талаар асуухыг хориглоно.</p> <p>68.2.11.Энэ хуульд заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага нэр дэвшигч, нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан, түүнд холбогдох баримттай танилцах, хөндлөнгийн хяналт тавих эрхтэй.</p> <p>72.1.Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох ажиллагааг Сонгуулийн ерөнхий хороо гүйцэтгэнэ.</p> <p>72.2.Сонгуулийн ерөнхий хороо санал тоолох ажиллагааг өөрийн байранд санал авах өдрийн 22:00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн</p>	
--	--	--

	<p>байгууллагын төлөөллийг байлцуулан ил тод, нээлттэй явуулна.</p> <p>72.3.Сонгуулийн ерөнхий хороо дараах ажиллагааг гүйцэтгэсний дараа саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийж саналыг тоолон санал хураалтын дүнг гаргаж нэн даруй мэдээлнэ:</p> <p>72.3.1.төв комиссоос ирүүлсэн саналын хуудас бүхий битүүмжилсэн дугтуйн нийт тоо нь санал авахад олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, эцсийн тооцоо гаргах;</p> <p>72.3.2.санал авахад зарцуулаагүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолох;</p> <p>72.3.3.битүүмжилсэн дугтуйнуудыг нээж, саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийхэд бэлэн болгох.</p> <p>72.4.Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох, дүн дамжуулах ажиллагааг явуулахад тухайн дипломат төлөөлөгчийн газарт санал тоолох төхөөрөмжийг Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрээр хэрэглэж болно.</p>	
<p>20.11.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.9-д заасан хугацаанд хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтад энэ хуулийн 20.9.1, 20.9.3, 20.9.4 дэх заалт, 23, 24 дүгээр зүйлд заасан үндэслэлээр оруулсан өөрчлөлтийг тусгаж сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ.</p>	<p>20.14.Энэ хуульд заасан сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх үйл ажиллагаанд хяналт тавих, нягтлан шалгах журмыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн, Сонгуулийн ерөнхий хорооны саналыг үндэслэн Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тагнуулын байгууллага хамтран батална.</p> <p>20 дугаар зүйлийн 20.13 дахь хэсэг:</p> <p>“Сонгогчдын нэрийн жагсаалтыг санал хураалтын өмнө болон дараа энэ хуульд заасны дагуу бүртгүүлсэн нам, эсвэл, бие даан нэр дэвшигч болон төрийн бус байгууллага нягтлан шалгах, хяналт тавих эрхтэй.”</p>	<p>Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага</p>
<p>“20.12.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.6.3, 20.6.7-д заасны дагуу хүргүүлсэн мэдээллийг үндэслэн гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, гадаадад санал авах өдрөөс гурваас</p>		<p>Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага</p>

<p>доошгүй хоногийн өмнө салбар комисст хүргүүлэх ажлыг төв комисстой хамтран зохион байгуулна.”</p>		
<p>62.12.Энэ хуулийн 62.11-д заасан хяналтын камерыг сонгогч саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахгүйгээр байрлуулж, сонгогчийг бүртгэх болон санал өгөх орчинд явагдаж байгаа үйл ажиллагааг баримтжуулна.</p>	<p>26/ 62.13.Санал авах байранд байрлуулах хяналтын камерт тавигдах шаардлага, түүнийг байрлуулах, ашиглах болон бичлэгийг хадгалах, хамгаалах, устгах журмыг цагдаагийн төв байгууллага Сонгуулийн ерөнхий хороотой хамтран батална.</p> <p>“62.11.Санал авах байрын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах зорилгоор санал авах байруудад хяналтын камер байрлуулна. Төв суурин газраас алслагдсан баг дахь санал авах байранд хяналтын камер байрлуулж болно.”</p>	
<p>63.1.Санал авах өдөр санал авах байранд өөрийн биеэр саналаа өгөх боломжгүй сонгогч санал авах өдрийг хүртэлх тав хоногийн хугацаанд санал авах байранд урьдчилан саналаа өгч болно.</p>	<p>63.2.Урьдчилан санал авах ажиллагааг санал авах байранд 09:00-17:00 цагийн хооронд авна.</p> <p>3.3.Сонгогч санал тэмдэглэх зааврын дагуу саналаа тэмдэглэж, саналын хуудсаа битүүмжилсэн саналын хайрцагт хийнэ.</p> <p>63.4.Урьдчилан санал авах ажиллагаанд энэ хуульд өөрөөр заагаагүй бол сонгогч санал авах байранд саналаа өгөх журмыг баримтлана.</p>	<p>Сонгуулийн хороод</p>

Нэг. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлоход дараах зарчмыг баримтлах ёстой. Үүнд

1. тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллагууд, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
2. байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах.

Холимог сонгуулийн тогтолцоог хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын гүйцэтгэх дараах чиг үүрэг, үйл ажиллагааг нэмэлтээр тусгажээ. Үүнд:

1. Хуулийн төслийн 4.3.1-т заасан сонгуулийн тойрогт нэр дэвшигчийн санал хураалтын дүн гаргах;
2. Тухайн тойрогт нэр дэвшсэн нийт нэр дэвшигчдийг авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргах;
3. Хуулийн төслийн 4.3.2-т заасан нээлттэй жагсаалтаар нэр дэвшигчийн санал хураалтын дүн гаргах;

4. Нам, эвсэл тус бүрээр авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргах, саналын тоо болон хувийг гаргах;
5. 3 хувийн босгыг даваагүй нам, эвслийн авсан нийт саналын хувийг тэнцүү хэмжээгээр хуваах, тооцож гаргасан хувиудын нийлбэрийг 38-д хувааж нэг суудалд ногдох саналын тоо, хувийг тооцож гаргах, их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилах;
6. Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэр гаргаж, Улсын Их Хурлын гишүүний үнэмлэх олгож, нийтэд мэдээлэх;
7. Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг сонгууль дууссанаас хойш 15 хоногийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;
8. Улсын Хурлын гишүүнээр сонгогдсонд тооцсон тухай шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо хүчингүйд тооцсон бол дахин санал хураалт явуулах;

Гадаадад оршин суугаа иргэдийн сонгох эрхийг хангахад төрийн байгууллагын гүйцэтгэх дараах чиг үүрэг, үйл ажиллагааг нэмэлтээр тусгажээ. Үүнд:

1. Төв комиссыг дарга, нарийн бичгийн дарга болон ес, эсхүл арван нэгэн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах;
2. Салбар комиссыг дарга болон хоёр, эсхүл дөрвөн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дипломат төлөөлөгчийн газрын дэргэд байгуулах;
3. Санал авах өдрийг Сонгуулийн ерөнхий хороо тогтоох;
4. Төв комисс болон салбар комиссыг ажиллах байр, нөхцөл, боломжоор хангах;
5. Улсын бүртгэлийн ерөнхий газар гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, гадаадад санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө салбар комисст хүргүүлэх;
6. Төв комисс нь санал авах ажиллагааг зохион байгуулах:
 - a. Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг төлөвлөх;
 - b. Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн саналын хуудас, сонгууль зохион байгуулах болон санал авахтай холбоотой бусад баримт бичгийг олон улсын буухиа шуудангаар салбар комисст хүргүүлэх;
 - c. Сонгуулийн ерөнхий хороо нь саналын хуудсыг уутны хамт битүүмжлэн, төв комиссоор дамжуулан гадаад улсад байгаа сонгогчдын санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө салбар комисст хүргүүлнэ;
 - d. Шаардлагатай тохиолдолд салбар комисст сургалт зохион байгуулах, төлөөлөгч томилон ажиллуулах;
 - e. Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, салбар комисст хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих, холбогдох журмын дагуу тайлагнах;
 - f. Эрх хэмжээнд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж, бичгээр хариуг өгөх;
 - g. Санал авах ажлыг зохион байгуулсан тухай тайлан, сонгуулийн бусад баримт бичиг, саналын хуудсыг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх;
7. Салбар комисс нь санал авах ажлыг зохион байгуулах:
 - a. Санал авах байрын хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;
 - b. Өөрийн байрладаг улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийг бүртгэж, сонгогчдын бүртгэлийг гарган төв комисст хүргүүлэх;

- c. Салбар комисс нь саналын хуудсыг бүрэлдэхүүнээрээ хүлээн авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж гарын үсэг зурах;
 - d. Санал авах байр, саналын хайрцаг, санал бэлтгэх бүхээг, санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;
 - e. Салбар комиссын бүрэлдэхүүн гадаадад санал авах өдөр тухайн улсын орон нутгийн цагаар 07:00 цагт ажиглагч, эсхүл сонгогчийн төлөөллийг байлцуулан саналын хайрцгийг нээж харуулан, шалган битүүмжилж, лацадсаны дараа салбар комиссын дарга хуульд заасан мэдээллийг хийж тэмдэглэл хөтлүүлэх;
 - f. Салбар комисс энэ хуулийн 67.1-д заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа санал авах ажиллагааг эхлүүлэх бөгөөд ингэхдээ сонгогчийн иргэний үнэмлэх, эсхүл үндэсний гадаад паспортыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэж, сонгогч бүрд саналын хуудсыг дугтуйн хамт олгох;
 - g. Саналын хуудас авсан сонгогчоор сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зуруулах;
 - h. Ажиглагч томилох эрх бүхий этгээд гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаанд хоёр хүртэл ажиглагчийг томилон ажиллуулж болно. Ингэх тохиолдолд төв комисс руу хүсэлт илгээж, үнэмлэх авах;
 - i. Салбар комисс санал авах ажиллагааны тухай тэмдэглэл хөтлөх.;
 - j. Санал хураалт дууссаны дараа битүүмжилсэн дугтуйтай саналын хуудас, санал авахад зарцуулагдаагүй үлдсэн, хураагдсан, хүчингүй саналын хуудас, санал хураалтын тухай салбар комиссын хуралдааны тэмдэглэл, сонгуулийн бусад баримт бичгийг төв комисст олон улсын буухиа шуудангаар нэн даруй хүргүүлэх;
8. Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох ажиллагааг Сонгуулийн ерөнхий хороо гүйцэтгэх;
 9. Сонгуулийн ерөнхий хороо санал тоолох ажиллагааг өөрийн байранд санал авах өдрийн 22:00 цагт эхэлж, ажиглагч, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг байлцуулан ил тод, нээлттэй явуулах;
 10. Сонгуулийн ерөнхий хороо дараах ажиллагааг гүйцэтгэсний дараа саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийж саналыг тоолон санал хураалтын дүнг гаргаж нэн даруй мэдээлэх;

Сонгуулийн зарчмыг (тэгш, хууль дээдлэх, шударга) хэрэгжүүлэх хүрээнд төрийн байгууллагын гүйцэтгэх дараах чиг үүрэг, үйлдлүүдийг нэмэлтээр тусгажээ. Үүнд:

1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтад зохих өөрчлөлтийг тусгаж сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлэх;
2. Хяналтын камерыг сонгогч саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахгүйгээр байрлуулж, сонгогчийг бүртгэх болон санал өгөх орчинд явагдаж байгаа үйл ажиллагааг баримтжуулах;

Урьдчилсан санал авах ажиллагааны хүрээнд төрийн байгууллагын гүйцэтгэх дараах чиг үүрэг, үйлдлүүдийг нэмэлтээр тусгажээ. Үүнд:

1. Санал авах өдөр санал авах байранд өөрийн биеэр саналаа өгөх боломжгүй сонгогч санал авах өдрийг хүртэлх тав хоногийн хугацаанд санал авах байранд урьдчилан саналаа өгч болох тул холбогдох зохион байгуулалтыг хийх.

Ажил үйлчилгээг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг нь тодорхойлно. Стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо хэт нарийвчлахгүйгээр ерөнхий байдлаар бүлэглэх зарчмыг баримтлав.

/Хүснэгт 2 /

Төрийн байгууллагын гүйцэтгэх ажил болон стандарт үйл ажиллагаа

Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Нээлттэй жагсаалтыг гаргах, зарлах	Нам эвслийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай тогтоолыг тухай бүр гаргах
	Тогтоолыг нийтэд мэдээлж, цахим сайт дээр байршуулах
	Нээлттэй жагсаалтыг хүлээн авч, эцэслэн, зарлах
Хуулийн төслийн 4.3.2-т заасан нээлттэй жагсаалтаар нэр дэвшигчийн санал хураалтын дүн гаргах	Нам, эвсэл тус бүрээр авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргах, саналын тоо болон хувийг гаргах
	3 хувийн босгыг даваагүй нам, эвслийн авсан нийт саналын хувийг тэнцүү хэмжээгээр хуваах, тооцож гаргасан хувиудын нийлбэрийг 38-д хувааж нэг суудалд ногдох саналын тоо, хувийг тооцож гаргах, их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилах
	Санал хураалтын дүнг мэдээлэх
Төв комиссыг дарга, нарийн бичгийн дарга болон ес, эсхүл арван нэгэн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах	Гадаад харилцааны яамны саналыг авах
	Сонгуулийн ерөнхий хорооны хуралдааныг зарлах, зохион байгуулах
	Тогтоолыг баталж, нийтэд мэдээлэх
Салбар комиссыг дарга болон хоёр, эсхүл дөрвөн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дипломат төлөөлөгчийн газрын дэргэд байгуулах	Төв комисс анхны хуралдаанаа зарлах, зохион байгуулах
	Салбар комиссыг байгуулахаар хэлэлцэх, шийдвэр гаргах, мэдээлэх
Санал авах өдрийг Сонгуулийн ерөнхий хороо тогтоох	Төв комисс гадаад улсад байгаа иргэдийн санал авах өдөр тогтоох саналаа Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх.
	СЕХ шийдвэр гаргаж, нийтэд мэдээлэх
Төв комисс болон салбар комиссыг ажиллах байр, нөхцөл, боломжоор хангах	Санал авах төхөөрөмжийг хүргүүлэх
Улсын бүртгэлийн ерөнхий газар гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, гадаадад санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө салбар комисст хүргүүлэх	Салбар комиссоос жагсаалтыг хүлээн авч, нэгтгэх
	Гадаад улсад саналаа өгөх сонгогчдыг Монгол Улсад саналаа өгөх сонгогчдын нэрийн жагсаалтаас хасах
	Гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, салбар комисст хүргүүлэх

Төв комисс нь санал авах ажиллагааг зохион байгуулах	Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг төлөвлөх
	Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн саналын хуудас, сонгууль зохион байгуулах болон санал авахтай холбоотой бусад баримт бичгийг олон улсын буухиа шуудангаар салбар комисст хүргүүлэх
	Сонгуулийн ерөнхий хороо нь саналын хуудсыг уутны хамт битүүмжлэн, төв комиссоор дамжуулан гадаад улсад байгаа сонгогчдын санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө салбар комисст хүргүүлнэ
	Шаардлагатай тохиолдолд салбар комисст сургалт зохион байгуулах, төлөөлөгч томилон ажиллуулах
	Эрх хэмжээнд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж, бичгээр хариуг өгөх
	Санал авах ажлыг зохион байгуулсан тухай тайлан, сонгуулийн бусад баримт бичиг, саналын хуудсыг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх
Салбар комисс нь санал авах ажлыг зохион байгуулах	Санал авах байрын хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх
	Өөрийн байрладаг улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийг бүртгэж, сонгогчдын бүртгэлийг гарган төв комисст хүргүүлэх
	Салбар комисс нь саналын хуудсыг бүрэлдэхүүнээрээ хүлээн авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж гарын үсэг зурах
	Санал авах байр, саналын хайрцаг, санал бэлтгэх бүхээг, санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах
	Салбар комиссын бүрэлдэхүүн гадаадад санал авах өдөр тухайн улсын орон нутгийн цагаар 07:00 цагт ажиглагч, эсхүл сонгогчийн төлөөллийг байлцуулан саналын хайрцгийг нээж харуулан, шалган битүүмжилж, лацадсаны дараа салбар комиссын дарга хуульд заасан мэдээллийг хийж тэмдэглэл хөтлүүлэх
	Салбар комисс энэ хуулийн 67.1-д заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа санал авах ажиллагааг эхлүүлэх бөгөөд ингэхдээ сонгогчийн иргэний үнэмлэх, эсхүл үндэсний гадаад паспортыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэж, сонгогч бүрд саналын хуудсыг дугтуйн хамт олгох.
	Сонгогч саналаа өгснийг илэрхийлэх тэмдэглэгээ хийх, сонгогчийн бүртгэлийн хуудас олгох
	Саналын хуудас авсан сонгогчоор сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зуруулах
	Ажиглагч томилох эрх бүхий этгээд гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаанд хоёр хүртэл ажиглагчийг томилон ажиллуулж болно. Ингэх тохиолдолд төв комисс руу хүсэлт илгээж, үнэмлэх авах
	Салбар комисс санал авах ажиллагааны тухай тэмдэглэл хөтлөх

	Санал хураалт дууссаны дараа битүүмжилсэн дугтуйтай саналын хуудас, санал авахад зарцуулагдаагүй үлдсэн, хураагдсан, хүчингүй саналын хуудас, санал хураалтын тухай салбар комиссын хуралдааны тэмдэглэл, сонгуулийн бусад баримт бичгийг төв комисст олон улсын буухиа шуудангаар нэн даруй хүргүүлэх
Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох ажиллагааг Сонгуулийн ерөнхий хороо гүйцэтгэнэ	Сонгуулийн ерөнхий хороо санал тоолох ажиллагааг өөрийн байранд санал авах өдрийн 22:00 цагт эхлэх
	төв комиссоос ирүүлсэн саналын хуудас бүхий битүүмжилсэн дугтуйн нийт тоо нь санал авахад олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, эцсийн тооцоо гаргах;
	санал авахад зарцуулаагүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолох;
	битүүмжилсэн дугтуйнуудыг нээж, саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийхэд бэлэн болгох.
	санал хураалтын дүнг гаргаж нэн даруй мэдээлнэ
Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтад зохих өөрчлөлтийг тусгаж сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлэх	Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулж эцэслэх Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлэх
Хяналтын камерыг сонгогч саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахгүйгээр байрлуулж, сонгогчийг бүртгэх болон санал өгөх орчинд явагдаж байгаа үйл ажиллагааг баримтжуулах	Хяналтын камерыг байршуулах
Санал авах өдөр санал авах байранд өөрийн биеэр саналаа өгөх боломжгүй сонгогч санал авах өдрийг хүртэлх тав хоногийн хугацаанд санал авах байранд урьдчилан саналаа өгч болох тул холбогдох зохион байгуулалтыг хийх	Урьдчилан санал авах ажиллагааг зохион байгуулах

Хоёр. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо Сонгуулийн Ерөнхий Хорооны холбогдох мэргэжилтнүүдээс ярилцлага авч, тэдгээрийн гүйцэтгэсэн ажил үйлчилгээгээр баримжаалж тогтоосон болно.

Дурдсан чиг үүргийн **тохиолдлын тоог** тогтоох боломжтой гэж үзэж байна. Тогтоох боломжтой тохиолдлын тоонд статистик мэдээллийн баримттай болон судалгаагаар тогтоож болох ажил үйлчилгээгээр хамаарна.

Сонгуулийн ажиллагаа нь төрийн олон байгууллагуудын оролцооны үндсэн дээр амжилттай явагдаж дуусдаг тул төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг тогтоохдоо хүрээгээр нь 4 бүлэгт ангилж, хүрээ тус бүрт төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн стандарт үйл ажиллагааг дээрх хэсэгт тогтоосон билээ. 4 хүрээ бүрт голлох чиг үүргийг гүйцэтгэж буй байгууллагын тоо, давтамж өөр байх тул хүрээ бүрт ялгамжтай байдлаар **тохиолдлын тоог** тооцооллоо. Тухайлбал:

➤ Холимог сонгуулийн тогтолцоог хэрэгжүүлэхэд гүйцэтгэх төрийн байгууллагын стандарт үйл ажиллагааны тохиолдлын тоог **1** гэж авч үзлээ. Учир нь уг хүрээнд хамааруулсан стандарт үйл ажиллагааг Сонгуулийн Ерөнхий Хороо сонгуулийн жил бүр нэг удаа гүйцэтгэхээр байна. Тухайлбал, саналыг тоолох, дүн гаргах, мэдээлэх гэх мэт.

➤ Гадаадад оршин суугаа иргэдийн сонгох эрхийг хангахад Төв комисс болон салбарын комисс голлох чиг үүргийг гүйцэтгэж байна. Төв комисс улсын хэмжээнд 1 байх тул түүний гүйцэтгэх стандарт үйл ажиллагааны тохиолдлын тоог **1** гэж үзнэ. Харин салбар комисс буюу Дипломат төлөөлөгчдийн газрын дэргэд байгуулагдах түр комиссын гүйцэтгэх стандарт үйл ажиллагааны тохиолдлын тоог **45** гэж үзлээ.

Харин сонгогч бүрт төрийн байгууллагаас үзүүлэх стандарт үйл ажиллагааны (жишээлбэл, бүртгэх) тохиолдлын тоог гадаад улсад оршин суугаа сонгуулийн насанд хүрсэн иргэдийн тоогоор тооцов.

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа иргэдийн тоо 91 168 байна. Тооллогын үед гадаадад байнга оршин суугаа хүмүүсийн 45.4 хувь нь суралцахаар, 8.0 хувь нь суурьшихаар, 13.4 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, 2.2 хувь нь албан томилолтоор, 14.9 хувь нь ажиллахаар, 13.6 хувь нь гэр бүлийн шалтгаанаар, 2.5 хувь нь бусад шалтгаанаар гадаадад оршин сууж байна. Уг тооллогын дүнгээс үзвэл 0-19 насны 16,625 иргэн байгаагад гадаадад оршин суугаа нийт иргэдийн тооноос хасвал сонгуульд оролцох боломжтой иргэдийн тоог ойролцоогоор тооцох боломжтой гэж үзлээ. Сонгуулийн насанд хүрсэн иргэдийн тоо 74,543 байна. Гэсэн хэдий ч 2020 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнгээс үзэхэд 7,394 иргэн гадаад улсад сонгууль өгөхөөр бүртгүүлсэнд үндэслэн 7,500 иргэн сонгууль өгнө хэмээн ойролцоогоор авч үзэв.

➤ Санал өгөх орчинд камер байршуулахтай холбоотой стандарт үйл ажиллагааны тохиолдлын тоог сонгуулийн хороодын тоогоор тодорхойлов.

Сонгуулийн ерөнхий хорооны статистикаас үзвэл улсын хэмжээнд сүүлийн 3 ээлжит сонгуулиар дунджаар ¹ 2100 хэсгийн хороо, 16421 хүний

¹ 2020 оны УИХ-ын ээлжит сонгууль – 2070 хэсэг байгуулагдаж, 16152 гишүүнтэйгээр бүрэлдэхүүнтэй байсан.

бүрэлдэхүүнтэйгээр ажилласан байна. Дээрх хүрээнд хамаарах зохицуулалтуудыг салбар комисс мөн хэрэгжүүлэх үүрэгтэй тул тохиолдлын тоог 2145 (+ 45) гэж үзлээ.

Сонгогчдын нэрийн жагсаалтад зохих өөрчлөлтийг тусгаж улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлэх ажиллагааны **тохиолдлын тоог 1** гэж үзэв.

- Урьдчилан санал авах ажиллагаа нь сонгуулийн өдрөөс өмнө эхэлнэ. Хуулийн төсөлд зааснаар санал авах өдөр санал авах байранд өөрийн биеэр саналаа өгөх боломжгүй сонгогч санал авах өдрийг хүртэлх тав хоногийн хугацаанд санал авах байранд урьдчилан саналаа өгч болох бөгөөд урьдчилан санал авах ажиллагааг санал авах байранд 09:00-17:00 цагийн хооронд авна. 5 хоногийн хугацаанд дээрх ажиллагааг үргэлжилнэ гэж үзсэн болно.

/Хүснэгт 3/

Стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Хуулийн төслийн 4.3.2-т заасан нээлттэй жагсаалтаар нэр дэвшигчийн санал хураалтын дүнг гаргах	Нам, эвсэл тус бүрээр авсан саналынх нь тоогоор дараалалд оруулан жагсаалт гаргах, саналын тоо болон хувийг гаргах 3 хувийн босгыг даваагүй нам, эвслийн авсан нийт саналын хувийг тэнцүү хэмжээгээр хуваах, тооцож гаргасан хувиудын нийлбэрийг 38-д хувааж нэг суудалд ногдох саналын тоо, хувийг тооцож гаргах, их үлдэгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилах Санал хураалтын дүнг мэдээлэх	1440	1	1440
Төв комиссыг дарга, нарийн бичгийн дарга болон ес, эсхүл арван нэгэн гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах	Гадаад харилцааны яамны саналыг авах	5,040	1	5,040
	Сонгуулийн ерөнхий хорооны хуралдааныг зарлах, зохион байгуулах	960	1	960
	Тогтоолыг баталж, нийтэд мэдээлэх	60	1	60
Салбар комиссыг дарга болон хоёр, эсхүл дөрвөн	Төв комисс анхны хуралдаанаа зарлах, зохион байгуулах	960	1	960

2020 оны ОНС – 2148 хэсэг байгуулагдаж, 16362 хүний бүрэлдэхүүнтэйгээр, 2021 оны МУЕ сонгууль – 2087 хэсэг байгуулагдаж, 16750 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилласан байна.

гишүүний бүрэлдэхүүнтэйгээ р дипломат төлөөлөгчийн газрын дэргэд байгуулах	Салбар комиссыг байгуулахаар хэлэлцэх, шийдвэр гаргах, мэдээлэх	260	1	260
Санал авах өдрийг Сонгуулийн ерөнхий хороо тогтоох	Төв комисс гадаад улсад байгаа иргэдийн санал авах өдөр тогтоох саналаа Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх.	5,040	1	5,040
	СЕХ шийдвэр гаргаж, нийтэд мэдээлэх	260	1	260
Төв комисс болон салбар комиссыг ажиллах байр ² , нөхцөл, боломжоор хангах	Санал авах төхөөрөмжийг хүргүүлэх	43,200	1	43200
Улсын бүртгэлийн ерөнхий газар гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, гадаадад санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө салбар комисст хүргүүлэх ³	Салбар комиссоос жагсаалтыг хүлээн авч, нэгтгэх	43,200	1	43200
	Гадаад улсад саналаа өгөх сонгогчдыг Монгол Улсад саналаа өгөх сонгогчдын нэрийн жагсаалтаас хасах	10,080	1	10080
	Гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж, салбар комисст хүргүүлэх	10,080	1	10080
Төв комисс нь санал авах ажиллагааг зохион байгуулах	Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг төлөвлөх	43,200	1	43200
	Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн саналын хуудас, сонгууль зохион байгуулах болон санал авахтай холбоотой бусад баримт бичгийг олон улсын буухиа шуудангаар салбар комисст хүргүүлэх	10,080	1	10080
	Сонгуулийн ерөнхий хороо нь саналын хуудсыг уутны хамт битүүмжлэн, төв комиссоор дамжуулан гадаад улсад байгаа сонгогчдын санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө салбар комисст хүргүүлнэ	10,080	1	10080
	Шаардлагатай тохиолдолд салбар комисст сургалт зохион байгуулах, төлөөлөгч томилон ажиллуулах	5,760	1	5760
	Эрх хэмжээнд хамаарах асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэж, бичгээр хариуг өгөх	10,080	1	10,080

² Улсын их хурлын сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.7.

³ Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хорооны мэдээлэл(<https://www.gec.gov.mn/voter/3140>)

Сүүлд үзсэн огноо:2023.03.18

	Санал авах ажлыг зохион байгуулсан тухай тайлан, сонгуулийн бусад баримт бичиг, саналын хуудсыг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх	20,160	1	20160
Салбар комисс нь санал авах ажлыг зохион байгуулах	Санал авах байрын хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх	20,160	45	907200
	Өөрийн байрладаг улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэдийг бүртгэж, сонгогчдын бүртгэлийг гарган төв комисст хүргүүлэх	30,240	45	1360800
	Салбар комисс нь саналын хуудсыг бүрэлдэхүүнээрээ хүлээн авч, энэ тухай тэмдэглэл үйлдэж гарын үсэг зурах	120	45	5400
	Санал авах байр, саналын хайрцаг, санал бэлтгэх бүхээг, санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах ⁴	4,320	45	194400
	Салбар комиссын бүрэлдэхүүн гадаадад санал авах өдөр тухайн улсын орон нутгийн цагаар 07:00 цагт ажиглагч, эсхүл сонгогчийн төлөөллийг байлцуулан саналын хайрцгийг нээж харуулан, шалган битүүмжилж, лацадсаны дараа салбар комиссын дарга хуульд заасан мэдээллийг хийж тэмдэглэл хөтлүүлэх	30	45	1350
	Салбар комисс энэ хуулийн 67.1-д заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа санал авах ажиллагааг эхлүүлэх бөгөөд ингэхдээ сонгогчийн иргэний үнэмлэх, эсхүл үндэсний гадаад паспортыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэж, сонгогч бүрд саналын хуудсыг дугтуйн хамт олгох.	10	7500	75000
	Сонгогч саналаа өгснийг илэрхийлэх тэмдэглэгээ хийх, сонгогчийн бүртгэлийн хуудас олгох	10	7500	75000
	Саналын хуудас авсан сонгогчоор сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зуруулах	3	7500	22500

⁴ Монгол Улсын их хурлын сонгуулийн тухай хуурьд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 64 дүгээр зүйлийн 64.3.

	Ажиглагч томилох эрх бүхий этгээд гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагаанд хоёр хүртэл ажиглагчийг томилон ажиллуулж болно. Ингэх тохиолдолд төв комисс руу хүсэлт илгээж, үнэмлэх авах	4,320	45	194400
	Салбар комисс санал авах ажиллагааны тухай тэмдэглэл хөтлөх	960	45	43200
	Санал хураалт дууссаны дараа битүүмжилсэн дугтуйтай саналын хуудас, санал авахад зарцуулагдаагүй үлдсэн, хураагдсан, хүчингүй саналын хуудас, санал хураалтын тухай салбар комиссын хуралдааны тэмдэглэл, сонгуулийн бусад баримт бичгийг төв комисст олон улсын буухиа шуудангаар нэн даруй хүргүүлэх	10,080	45	453600
Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох ажиллагааг Сонгуулийн ерөнхий хороо гүйцэтгэнэ	Сонгуулийн ерөнхий хороо санал тоолох ажиллагааг өөрийн байранд санал авах өдрийн 22:00 цагт эхлэх	10	1	10
	төв комиссоос ирүүлсэн саналын хуудас бүхий битүүмжилсэн дугтуйн нийт тоо нь санал авахад олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, эцсийн тооцоо гаргах;	30	45	1350
	санал авахад зарцуулаагүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолох;	5	45	225
	битүүмжилсэн дугтуйнуудыг нээж, саналын хуудсыг санал тоолох төхөөрөмжид хийхэд бэлэн болгох.	1,250	45	56250
	санал хураалтын дүнг гаргаж нэн даруй мэдээлнэ	60	1	60
Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтад зохих өөрчлөлтийг тусгаж сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан	Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулж эцэслэх	10080	1	10080
	Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь газар, хэлтсээр дамжуулан хэсгийн хороонд хүргүүлэх	60	2100	126000

хэсгийн хороонд хүргүүлэх				
Хяналтын камерыг сонгогч саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэхэд саад учруулахгүйгээр байрлуулж, сонгогчийг бүртгэх болон санал өгөх орчинд явагдаж байгаа үйл ажиллагааг баримтжуулах	Хяналтын камерыг байршуулах	240	2145	514800
Санал авах өдөр санал авах байранд өөрийн биеэр саналаа өгөх боломжгүй сонгогч санал авах өдрийг хүртэлх тав хоногийн хугацаанд санал авах байранд урьдчилан саналаа өгч болох тул холбогдох зохион байгуулалтыг хийх	Урьдчилан санал авах ажиллагааг зохион байгуулах	7,200	2100	15120000
Нийт				19,381,565

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /хөдөлмөрийн хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу нэмэгдэх орон тоо гарна.

/Хүснэгт 4/

Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Төрийн байгууллага	19381565	96.000	201.8

Гурав. Гаргах зардлыг урьдчилан тооцох

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн улмаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардал⁵-г юун түрүүнд тооцно.

Аюулгүй байдал, хамгаалалтын тасгийн нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Сонгуулийн ерөнхий хорооны албан хаагчдын жилийн дундаж цалинг 11,100,204 төгрөг, Элчин сайдын яам, консул, дипломат төлөөлөгчдийн газрын албан болон Улсын бүртгэлийн байгууллагын ажилтны (ТЗ) жилийн дундаж цалинг 17,226,080.4 төгрөг гэж үзэн, тэдгээрийн дундаж болох 14,163,142 төгрөгөөр нэг албан хаагчийн цалингийн зардлыг тооцлоо.

Сонгуулийн хэсгийн хороонд ойролцоогоор 8 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг.

Нэг албан хаагчийн нэг жилийн цалингийн зардал нь **14,163,142** төгрөг байна. Түүнд ногдох НДШ нь **1,770,392** төгрөг. Иймд, нэг ажилтанд ногдох нийт цалингийн зардал нь **15,933,534** төгрөг байна.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

/Хүснэгт 5/

Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
Төрийн байгууллага	201.8	14,163,142	2,858,122,055

⁵ Хүний нөөцийн зардал гэдэгт тухайн үүргийг гүйцэтгэх төрийн албан хаагчийн авч болох бүх нэмэгдэл, тусламж, төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн дунджаар гаргасан зардал хамаарна.

Дөрөв. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, Материаллаг дундаж зардал, Бусад зардлыг нэмснээр нийт зардал илэрхийлэгдэнэ.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардлууд орно.

/Хүснэгт 6 /

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн төсөв

№	Үзүүлэлт, зардлын агуулга		Төсөв
2	Саналын хуудас хэвлүүлэх, хамгаалах, хүргүүлэх зардал /Хуулийн 10.1.2/	2.1. Саналын хуудас хэвлүүлэх	3,104,321,220.0
11	Сонгуулийн хороодын ажилтан, мэдээллийн технологийн багийн болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын хоолны зардал /Хуулийн 10.1.10/	11.1. Сонгуулийн хороодын ажилтны сонгуулийн хороонд ажилласан хугацааны хоолны мөнгө	1,538,810,000.0
		11.2. Мэдээллийн технологийн баг болон даамал, нөөц даамлын хоолны мөнгө	189,350,000.0

УИХ-ын Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль, МУ-ын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд нэг сонгогч 1 саналын хуудсыг бөглөсөн. Нэг саналын хуудсыг /УИХ-д 1350₮+НӨАТ, МУЕ 1320₮+НӨАТ/ 1452-1485 төгрөгөөр хэвлэсэн байна. Холимог тогтолцооны шилжих тохиолдолд саналын хуудасны хэмжээ 14 инчээс 22 инч болон нэмэгдэнэ. Урьдчилсан байдлаар саналын хуудасны хэвлэлтийн зардал 3 дахин нэмэгдэхээр байна.

Урьдчилан санал авах ажиллагааг сонгууль болох өдрөөс 5-иас ихгүй хоногийн өмнө эхлүүлэхээр хуулийн төсөлд заасан. Иймд сонгуулийн хороодын ажилтан, мэдээллийн технологийн багийн болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын ажилласан хоолны зардал нэмэгдэнэ. /Мөнгөн урамшуулал нэмэгдэхгүй гэж тооцсон болно./ Гэвч урьдчилан санал хураалттай холбоотойгоор цагдаагийн албан хаагч болон улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хоолны зардал нэмэгдэнэ.

/Хүснэгт 7 /

Хуулийн төсөлд тусгагдсан нэмэлт зохицуулалттай холбоотойгоор үүсэх материаллаг зардал

№	Үзүүлэлт, зардлын агуулга		Төсөв
2	Саналын хуудас хэвлүүлэх, хамгаалах, хүргүүлэх зардал /Хуулийн 10.1.2/	2.1. Саналын хуудас хэвлүүлэх	9,312,963,660
11	Сонгуулийн хороодын ажилтан, мэдээллийн технологийн багийн	11.1. Сонгуулийн хороодын ажилтны сонгуулийн хороонд ажилласан хугацааны хоолны мөнгө	2,308,215,000*

болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын ажилласан хугацааны хоолны зардал /Хуулийн 10.1.10/	11.2. Мэдээллийн технологийн баг болон даамал, нөөц даамлын хоолны мөнгө	284,025,000*
	Цагдаагийн албан хаагч болон улсын бүртгэлийн төлөөлөгчийн хоолны зардал	1,128,750,000*
Нийт		13,033,953,660

* Сонгуулийн хороодын ажилтан, мэдээллийн технологийн багийн болон ажлын хэсгийн гишүүн, даамал, нөөц даамлын ажилласан хугацааны хоолны зардлын талаарх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хорооноос авсан болно.

Дээрх материаллаг зардал нь гагцхүү Монгол Улсад явагдах сонгуулийн ажиллагаанд хамаарах зардал юм. Иймд гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажиллагааны зардлыг дор зааснаар тодорхойлж, бусад зардлаар тооцов.

/Хүснэгт 8 /

Гадаад улсад байгаа иргэдийн санал авахад учрах зардал буюу Бусад зардал⁶

	Зардлын төрөл	Зориулалт	Тоо/ давтамж	Төсөвлө- сөн үнэ /нэг бүрт/	Нийт үнэ
1	Сургалтын зардал /цахим/	Салбар комиссын гишүүдийг сургах	1	0	0
2	Бичиг хэргийн зардал	Төв комисс	1	1,000,000	1,000,000
		Салбар комисс	45	531,000	23,895,000
3	Шуудан холбооны зардал	Төв комисс	1	1,000,000	1,000,000
		Салбар комисс	45	354,000	16,930,000
4	Сурталчилгааны зардал	Төв комисс	1	8,000,000	8,000,000
		Салбар комисс	45	885,000	39,825,000
5	Санал авах бүхээг, хайрцаг бэлтгэх	Салбар комисс	100	180,540	18,054,000
6	Санал тэмдэглэх, хэвлэх иж бүрдэл төхөөрөмж /таблет, принтер, карт/:	Салбар комисс	65	6,018,000	391,170,000
7	Ачааны зардал	Санал тоолох төхөөрөмж зөөх /2 тал/	65x12кг	70,800	55,224,000
		Санал тэмдэглэх төхөөрөмж зөөх /2 тал/	65x8кг	70,800	36,816,000

⁶ Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн төсвийн төслийн хэсгээс /Урьдчилсан байдлаар/.

8	Онгоцны буудал хүртэлх унааны зардал		45	354,000	15,930,000
9	Урамшуулал:	Салбар комиссын гишүүнд олгох	225 хүн	550,000	123,750,000
10	Томилолтын зардал (1 ДТГ-т 3 хүн /даамал, сонгуулийн хороо, Төв комиссоос тус бүр нэг хүн/ томилогдоно)	Унааны зардал	135 (45*3)	4,500,000	607,500,000
		Томилолт	135	8,850,000	1,194,750,000
Нийт					2 527 546 825

Нийт зардлыг тооцох

/Хүснэгт 9 /

Нэг албан хаагчид ногдох зардал

Төрөл	Хүний нөөцийн зардал	Материаллаг зардал	Бусад зардал
Нийт Зардлын хэмжээ	2,858,122,055	13,033,953,660	2 527 546 825
Нийт зардал			18,419,622,540

Эндээс хүний нөөцийн зардал буюу 2,858,122,055 нь төрөөс шууд гарахгүй боловч төрийн байгууллагын ажилтнуудын сонгуулийн ажилд зарцуулах нийт хугацаанд ногдох дүн гэдгийг анхаарах нь зүйтэй. Харин материаллаг (саналын хуудас болон урьдчилан санал авах ажиллагаатай холбоотой хоолны зардал) болон бусад зардал буюу гадаадад байгаа иргэдийн санал авахад үүсэх зардлыг төрөөс зайлшгүй гаргана.

Боловсруулсан хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд төрийн байгууллагад **18,419,622,540** төгрөгийн зардал гарахаар байна.

Тав. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хувилбарыг нягтлах шатанд хуулийн төсөлд шинээр нэмэгдэж байгаа буюу өөрчлөгдөж буй зохицуулалттай холбоотой төрд үүсэх зардлыг хэрхэн багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар боломж байгаа эсэхийг нягталж үзнэ.

Хувилбарыг нягтлах ажлыг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэнэ:

1. Стандарт үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэх боломжтой эсэх;
 2. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;
 3. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх;
 4. Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх;
- Стандарт үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэх боломжтой эсэх
Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажиллагааг цахимаар гүйцэтгэх боломжтой байж болох юм. Тус зохицуулалтын хүрээнд тогтоосон сонгуулийн

санал авах өдрийг үндэслэн гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах төв комиссын саналыг харгалзан сонгуулийн төв байгууллага тогтоох бөгөөд санал авах өдөр нь хоёр хүртэл өдөр байж болохоор зохицуулсан. Хуулийн төслийн зохицуулалтын хүрээнд явагдах процесс ажиллагааны явцад 2 527 546 825 төгрөгийн зардал гарахаар тооцоологдож байна. Гадаад улсад байгаа иргэдээс цахим хэлбэрээр сонгуулийн санал авах, эсхүл төлөөлөгчөөр дамжуулан саналаа өгсөн тохиолдолд дээрх зардлыг тодорхой хэмжээнд хэмнэх боломжтой.

- Тохиолдлыг тоог багасгах боломж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.9-д: “шууд буюу төлөөлөгчийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй... Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ.” гэж үндсэн эрх болгон зохицуулснаас харахад тохиолдлын тоог багасгах нь үндсэн эрхэд халдаж байгаа явдал тул тоог багасгах боломжгүй гэж дүгнэлээ.

- Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж бий эсэх

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд зохицуулагдаж байгаа урьдчилан санал авах ажиллагааны дагуу 5 хоногийн хугацаанд сонгуулийн өдрөөс өмнө авахаар хуульчилсан. Хуулийн төсөлд зааснаар санал авах өдөр санал авах байранд өөрийн биеэр саналаа өгөх боломжгүй сонгогч санал авах өдрийг хүртэлх тав хоногийн хугацаанд санал авах байранд урьдчилан саналаа өгч болох бөгөөд урьдчилан санал авах ажиллагааг санал авах байранд 09:00-17:00 цагийн хооронд авна. Уг зохицуулалтын зорилго нь сонгууль өгч байгаа иргэдийн тоог нэмэх хэдий ч зардлыг тухайлан хэмнэж чадахгүй гэж харж байна. Тодруулбал, орон нутагт бүртгэлтэй хэдий ч Улаанбаатар хотод амьдардаг сонгогчид саналаа өгөх тав хоногтоо багтаан очиж саналаа өгөхөд эдийн засгийн талаас ялгамжгүй. Харин тухайн иргэн одоо оршин суугаа газраа сонгуулиа өгөөд Сонгуулийн ерөнхий хороо дотоод сүлжээний дагуу саналыг шилжүүлэх нь үр дүнтэй байж болно.

- Мэдээллийн зарим агуулгаас татгалзаж болох эсэх

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын 38 гишүүнийг энэ хуульд заасны дагуу сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн нэр дэвшигчдийн жагсаалтаас сонгох зохицуулалттай бөгөөд энэ жагсаалт нь нээлттэй болон хаалттай байж болдог. Хаалттай жагсаалт гаргаснаар зарим агуулгаас татгалзах боломжтой хэдий ч арчилсан Үндсэн хуулийн гол агуулга нь нээлттэй, тэгш, шударга байдлаар сонгууль явагдахад оршдог. Иймд татгалзах боломжгүй гэж үзлээ.

ИРГЭНД УЧРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Сонгох, сонгогдох эрх нь гагцхүү Монгол Улсын иргэний эдлэх эрх тул энэхүү зардлын тооцооны тайлангаар гагцхүү иргэнд үүсэх зардлыг тооцоолсон болно.

Иргэнд үүсэх зардлын тооцоог дараах алхмын хүрээнд хийнэ. Үүнд:

1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох
2. Зардал тооцох
3. Тоон үзүүлэлтийг тооцох
4. Зардлын дүнг тооцож гаргах
5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах
6. Нэмэлт зардал тооцох

Нэг. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

Тус хуулийн төсөлд одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн зүйл заалтад өөрчлөлт орсон болон нэмж туссан, сонгуульд оролцсон иргэний зардалд нөлөөлөх зүйл заалтыг дараах хүснэгтээр харуулав.

/Хүснэгт 10/

Иргэний гүйцэтгэх ажил болон стандарт үйл ажиллагаа

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төслийн дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Гадаад улсад саналаа өгч буй иргэн ⁷	Сонгуульд оролцох талаар мэдэгдэх	Тухайн улс дахь Монгол улсын дипломат төлөөлөгчийн газарт санал өгөх талаар мэдэгдэх /цахимаар/

Хоёр. Зардал тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр иргэнд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана. Иргэний зүгээс үүргийг хэрэгжүүлэх хүрээнд хийх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлж, тус бүрт зарцуулах хугацаа болон ажлын хөлсийг тогтоох шаардлагатай.

Зардлыг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлох;
2. Тухайн үйлдэлд зарцуулагдах хугацааг тогтоох;
3. Тухайн үйлдлийг хийх ажилтны ажлын хөлсийг тодорхойлох.

Иргэн, хуулийн этгээдэд үүсэх захиргааны зардлыг тооцохдоо стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэнэ. Мөн тус жагсаалтад багтахгүй үйл ажиллагаанд жагсаалт гаргаж, ажиглалт хийх, ярилцлага хийх зэрэг судалгааны арга ашиглан тухайн

⁷ Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хорооны мэдээлэл (<https://www.gec.gov.mn/voter/3140>)
Сүүлд үзсэн огноо:2023.03.18

үүргийг гүйцэтгэх хугацааг тодорхойлно. Цаг хугацааг тооцохдоо зарцуулах хугацааг минутаар тооцож гаргана.

Ажлын хөлсийг тооцох

Ажлын хөлсийг тогтоохдоо аж ахуйн нэгжид ажиллаж буй нэг ажилтны сарын дундаж цалин хөлсийг баримжаалан тооцох бөгөөд зарим тохиолдолд тусгай мэдлэг, мэргэжил, ур чадвар шаардсан үйл ажиллагаанд өндөр цалин, хангамж олгож буй тохиолдлыг анхаарч авч үздэг.

Мөн нэг сард ажиллах хугацааг тооцож гарган үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааснаар тухайн ажилтанд ногдох ажлын хөлсийг тооцож гаргана.

/Хүснэгт 11 /

Аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин⁸

	2020	2021	2022-III
Аж ахуй нэгж байгууллагын сарын дундаж цалин	977,800	1,058,900	1,361,400

Аж ахуй нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол өссөн үзүүлэлтэй байна. Сүүлийн таван жилийн дундаж цалинд үндэслэн ажилтны нэг сарын ажлын хөлсийг 1,132,700 төгрөг байхаар, ажиллах хугацааг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлд ердийн нөхцөлд ажлын цагийг 7 хоногт 40 цагаас, нэг өдрийн ажлын цаг 8 цагаас илүүгүй байхаар зохицуулсан байдаг. Үүнээс харахад нэг ажилтан нэг сард ажлын 22 өдөр /22*8=176 цаг, 176*60=10560 минут/ ажилладаг байна.

Үндсэн цалин / Ажиллах хугацаа = Ажлын хөлс /төгрөг/

1,132,700 / 176 цаг = 6,435 төг /цагт/

1,132,700 / 10560 минут = 107 төг /мин/

/Хүснэгт 12/

Аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхэлж буй ажилтны ажлын хөлсийг цаг, минутаар

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төслийн дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа	Ажлын хөлс	Зардал
Гадаад улсад		Тухайн улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт санал	30	107	3,210

⁸ Үндэсний статистикийн хороо, Аж ахуй нэгж, байгууллагын ажилчдын сарын дундаж цалин, УБ, 2022. https://www.1212.mn/mn/statistic/statcate/48171320/table-view/DT_NS0_0400_023V1
Сүүлд үзсэн огноо: 2022.12.10

саналаа өгч буй иргэн	Сонгуульд оролцох талаар мэдэгдэх	өгөх талаар мэдэгдэх /цахимаар/			
Нийт					3,210.0

Гурав. Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хичнээн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлыг тоог давтамжийн тоогоор үржүүлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

1. Тухайн үүргийг хүлээх хуулийн этгээдийн тоо (Тохиолдлын тоо);
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо);

Дээрх чиг үүргийн **тохиолдлын тоог** тогтоох боломжтой гэж үзэж, энэхүү зардлын тооцооны тайлангийн 1 дэх хэсэгт заасан статистикийг ашиглан тогтоолоо.

Давтамжийн тоо: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн этгээдийн зүгээс мэдээлэл хүргүүлж байх хугацааг заагаагүй, харин тухай бүр гаргаж байхаар зохицуулсан тул давтамжийг 1 гэж авсан болно.

/Хүснэгт 13/

Чиг үүрэгтэй холбоотойгоор тохиолдлын тоо

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төслийн дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
Гадаад улсад саналаа өгч буй иргэн	Сонгуульд оролцох талаар мэдэгдэх	Тухайн улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт санал өгөх талаар мэдэгдэх /цахимаар/	1	1	1

Дөрөв. Зардлын дүнг тооцож гаргах

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргана.

/Хүснэгт 14/

Стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх зардал

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төслийн дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Зардал	Тоон үзүүлэлт	Нийт Зардал
Гадаад улсад санала өгч буй иргэн	Сонгуульд оролцох талаар мэдэгдэх	Тухайн улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт санал өгөх талаар мэдэгдэх /цахимаар/	3,210	7,394	23,734,740

2021 оны ерөнхийлөгчийн сонгуульд санал өгөхөөр гадаад улсаас 7,394 иргэн бүртгүүлсэн байна⁹. Уг тоон баримтад үндэслэн нийт иргэдэд 23,734,740 төгрөгийн зардал гаргах бөгөөд нэг иргэнд дунджаар 3,210 төгрөгийн зардал гарах төлөвтэй байна. Энэхүү зардал нь гагцхүү хуулийн төсөл дэх гадаад улсад сонгууль өгөхөөр шийдсэн иргэнд “үүрэг” болгосон зохицуулалтад хамаарах анхаарах нь зүйтэй. Сонгох эрхээ хэрэгжүүлэх нь гадаад улсад оршин сууж байгаа иргэний эрх юм. Иймд түүнтэй холбоотой зардлыг хуулийн төслийн зардлын тооцоонд оруулахгүй.

Тав. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт тодорхой шалгах асуултын дагуу зардлыг нь тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, аж ахуйн салбарт үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгалаа. Гадаадад оршин суугаа иргэн нь сонгууль өгөх эрхээ хэрэгжүүлэхээр шийдсэн тохиолдолд тухайн улс дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газарт санал өгөх талаар мэдэгдэж бүртгүүлэх үүрэг хүлээнэ. Хуулийн төсөлд тэдгээр иргэдийн бүртгүүлэх хүсэлтийг цахимаар хүлээж авах, шийдвэрлэх талаар тодорхой тусгаагүй байна. Иргэд санал өгөх талаар цахимаар мэдэгдэж, бүртгүүлсэн тохиолдолд иргэдэд учрах зардал, чирэгдлийг эрс багасгах, тэдгээрийн цаг хугацааг хэмнэх, сонгуулийн ирцийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.

Түүнчлэн “цахимаар бүртгүүлэх” тохиолдолд хэрхэн баталгаажуулах асуудлыг шийдвэрлээгүй байх бөгөөд бүртгэл, маягт цахимаар бөглүүлсэн тохиолдолд тэдгээрийн агуулга нь энгийн, ойлгомжтой, хэт олон мэдээлэл шаардаагүй байхад чиглэсэн байх ёстойг анхаарах нь зүйтэй.

Тохиолдлын тоо болон давтамжийг багасгах боломжгүй гэж үзлээ.

Зургаа. Нэмэлт зардлыг тооцох

Энэ хэсэгт Хуулийн төсөлд тусгагдсан сонгох эрхээ хэрэгжүүлэхэд аливаа хураамж, төлбөр төлөхгүй тул иргэнд бусад төрлийн нэмэлт зардал гарахгүй гэж тооцоолов.

⁹Ерөнхийлөгчийн сонгуулийн мэдээлэл (<https://ikon.mn/president/2021>) Сүүлд үзсэн огноо: 2023.03.18

ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү хуулийн төслийн зардлын тооцооны судалгаагаар хууль тогтоомжийн зохицуулалтын улмаас иргэн, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан тооцоолохыг зорилоо.

Судалгааны хүрээнд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгжилттэй холбогдон гарах иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагаас гарах зардлыг нэмэлт өөрчлөлт орсон зүйл заалт тус бүрээр тооцон боловсруулсан болно.

Хуулийн төсөлд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд хэд хэдэн зарчмын шинжтэй нэмэлт өөрчлөлт оруулахаар тусгажээ. Улмаар хуулийн төслийн хэрэгжилтийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагаас гарах зардлын тооцоог дараах байдлаар дүгнэж болохоор байна. Үүнд:

Нэгдүгээрт, Төрийн байгууллагаас гарах зардал:

Боловсруулсан хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд төрийн байгууллагад 18,419,622,540 төгрөгийн зардал гарахаар байна. Үүнд саналын хуудасны зардал, урьдчилан санал хураалттай холбогдон гарах зардал, гадаад улсад санал хураалт зохион байгуулах зардал зэрэг багтснаас гадна төсөлд дурдсан чиг үүргийг хэрэгжүүлэх хүний нөөцийн зардал хамаарна. Судалгааны явцад саналын хуудас хэвлэхтэй холбогдон гарах зардал нийт зардлын 50 хувийг эзлэж байгаа тул саналын хуудасны хэмжээ, тоог нэмэхээс илүүтэйгээр саналын хуудасны агуулгыг зөв тодорхойлоход анхаарах нь зүйтэй. Дээрх тохиолдолд 5-6 тэрбум төгрөгийн зардлыг хэмнэх боломжтой гэж үзэж байна.

Мөн Гадаад улсад буй иргэдээс санал авах ажиллагаанд комиссын томилолтын зардал, бүртгэлийн зардал, санал авах ажиллагааны зохион байгуулалтын зардал, комиссын урамшуулал, урсгал зардал гарахаар байна. Эдгээрийг дараах байдлаар тооцсон болно.

Хоёрдугаарт, Гадаад томилолтын зардал:

Гадаад улсад байгаа иргэдээс санал авахаар зохицуулсан Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг баталгаажуулах үүднээс авч үзвэл сайшаалтай байна. Үүнийг хэрэгжүүлэх процесс ажиллагаанд 2 527 546 825 төгрөгийн зардал гарахаар тооцоологдож байна.

Дээрх зардлын 1,802,250,000 төгрөг буюу 70 гаруй хувь нь 45 ДТГ бүрт 10 хоногийн хугацаатайгаар томилогдон ажиллах нийт 135 хүний томилолтын болон унааны зардлаас бүрдэнэ. Уг томилгоо нь төдийлөн ач холбогдолгүй тохиолдолд тус зардлыг бууруулах үүднээс тухайн ДТГ-н ажилтныг салбар комиссын бүрэлдэхүүнд оруулах эсхүл тухайн гадаад улсад оршин суугаа иргэдтэй гэрээ байгуулах замаар ажиллуулах томилолтын зардлыг хэмнэх боломжтой.

Гуравдугаарт, Бүртгэлийн зардал:

Гадаад улсад байгаа иргэн сонгуулийн бүртгэлийг урьдчилан хийлгэсэн байх ёстой. Уг ажиллагааг цахимаар гүйцэтгэх эсэхийг тодорхой зохицуулаагүй байна. Ийнхүү бүртгүүлэхэд нэг сонгогчоос 3,210 төгрөгийн зардал, нийт сонгогчоос 23,734,740 төгрөгийн зардал гаргах төлөвтэй байна. Гадаад улсад байгаа иргэдээс цахим хэлбэрээр сонгуулийн бүртгэл авах, эсхүл төлөөлөгчөөр дамжуулан санал өгсөн тохиолдолд дээрх зардлыг тодорхой хэмжээнд хэмнэх боломжтой.

Дөрөвдүгээрт, Зохион байгуулалтын зардал:

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд “Санал авах өдөр санал хураах байранд өөрийн биеэр саналаа өгөх боломжгүй сонгогч санал авах өдрийг хүртэлх тав хоногийн хугацаанд санал авах байранд урьдчилан саналаа өгч болох”-оор хуульчилсан. Урьдчилан санал хураах ажиллагааг хариуцах субъект, санал авах байршил, түүний зохион байгуулалт тодорхойгүй байна.

Тавдугаарт, Комиссын урамшуулал, урсгал зардал:

Сонгуулийн хорооны гишүүдэд нэмэгдэл урамшуулал олгохгүй гэж үзэж хороодын гишүүд, ажилчид, цагдаагийн албан хаагчийн хоолны зардлыг тооцсон болно.

Зургаадугаарт, Цагдаагийн албан хаагч болон улсын бүртгэлийн төлөөлөгчийн зардал:

Түүнчлэн Хүснэгт 7-д авч үзсэн нэмэлт өөрчлөлт холбоотойгоор цагдаагийн албан хаагч болон улсын бүртгэлийн төлөөлөгчийн хүрээнд нэмэлт зардал, төсвийн ачаалал үүсэж болзошгүй байгаа тул холбогдох тооцооллыг гүйцэтгэсэн болно.

Долоодугаарт, Иргэнд үүсэх зардал:

2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд санал өгөхөөр гадаад улсаас 7,394 иргэн бүртгүүлсэн байна¹⁰. Уг тоон баримтад үндэслэн сонгуулийн бүртгэлийг цахимаар хийх тохиолдолд нэг сонгогч дунджаар 3,210 төгрөг болох ба нийт сонгогчдын дүнгээр тооцоолбол 23,734,740 төгрөгийн зардал гарах төлөвтэй байна. Энэхүү зардал нь гагцхүү хуулийн төсөл дэх гадаад улсад сонгууль өгөхөөр бүртгүүлсэн иргэнд “үүрэг” болгосон зохицуулалтын хүрээнд тооцсон болно.

¹⁰ Ерөнхийлөгчийн сонгуулийн мэдээлэл (<https://ikon.mn/president/2021>). Сүүлд үзсэн огноо: 2023.03.18